

ТАНИЛЦУУЛГА

“Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хуулийн төслийн тухай

Согтуурах, мансуурах донтой, өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль 2000 онд батлагдсанаас хойш дөрвөн удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Өнгөрсөн хугацаанд тус хуулийг мөрдөн ажиллах явцад зарим заалт нь хэрэгжих боломжгүй болсон тул хасах, зарим зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох, шинээр зохицуулалт нэмэх, журмаар зохицуулж байгаа зарим асуудлыг хуульчлах шаардлагатай болсон нөхцөл байдал үүссэн учраас хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд тусгаж байгаа нэмэлт, өөрчлөлтийн дагуу хуулийн зорилтыг шинэчлэн томъёоллоо.

Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенци болон Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэн орсон. Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцид “Энэхүү конвенцийг соёрхон баталсан Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын гишүүн бүр албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг аль болох богино хугацаанд арилгах үүрэг хүлээнэ” гэжээ.

Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцид албадан буюу заавал хийлгэх хөдөлмөрийн аливаа хэлбэрийг хориглож, “...хүмүүжлийн арга хэрэгсэл болгох...” зэрэг зорилгоор ашиглахыг таслан зогсоохоор заасан.

Согтуурах, мансуурах донтой хүнийг шүүхийн шийдвэрээр албадан эмчлэх нь ял, шийтгэл оногдуулж байгаа биш бөгөөд донтой болсны улмаас өөртөө болон бусдад аюул учруулах эрсдэлтэй байгааг нь харгалзан гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс сэргийлэх, эмчлэх зорилгоор захиргааны журмаар албадлага хэрэглэж байгаа учраас дээрх конвенцид нийцүүлэн албадан хөдөлмөр хийлгэхтэй холбогдсон зохицуулалтыг хассан.

Хуулийн төслийн нэрийг “Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай” хэмээн өөрчилж, хэрэгжүүлэх чиг үүргийг нь харгалзан “Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар” гэснийг төсөлд “Албадан эмчлэх эмнэлэг” гэж нэрлэсэн.

Одоогийн мөрдөж байгаа хуульд Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяалалд байдаг бөгөөд түүний албадан эмчлэх мэргэжлийн удирдлагыг эрүүл мэндийн байгууллага хэрэгжүүлнэ гэж заасан боловч мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажил хангалтгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад эмчлэх мэргэжлийн удирдлага, боловсон хүчнээр хангах, мэргэшүүлэх, давтан сургах чиг үүрэг байдаггүй тул мэргэжлийн удирдлагаар хангах эрүүл мэндийн байгууллагыг

Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх төв байгууллага байхаар зааж, уг байгууллагын хэрэгжүүлэх ажлыг хуулийн төсөлд тодорхой тусгалаа.

Эрүүл мэндийн сайд, Улсын ерөнхий прокурорын 2005 оны 188 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх журам”-д Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар нь сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандартад зааснаар зохион байгуулагдан ажиллахаар заасан байна.

Одоогийн байдлаар Албадан эмчлэх эмнэлэг улсын хэмжээнд нэг байгаа бөгөөд бүх аймаг, нийслэлээс ирж байгаа эмчлүүлэгчийн тоо өсөн нэмэгдэж, тус газрын хүчин чадал хүрэлцэхгүй байгаагаас үзэхэд цаашид энэ чиглэлийн эмчилгээ, үйлчилгээ явуулдаг газрын тоог нэмэх, эсхүл бусад эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж, бодлогын хэмжээнд шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн холбогдох заалтыг харгалзан хуулийн төсөлд Албадан эмчлэх эмнэлгийг төрөлжсөн тусгай мэргэшлийн эмнэлэг байхаар тусгалаа.

Албадан эмчлэх эмнэлгээс гаргасан судалгаанаас үзэхэд согтуурах донтой өвчтэйн улмаас эмчлүүлэхээр ирж байгаа хүмүүсийн 50-60% нь ямар нэгэн суурь өвчтэй ирдэг бөгөөд үүнээс болж эмчилгээнд хамрагдах боломжгүй, эсхүл эмчилгээг дундаас нь зогсоох болдог байна. 2010-2013 оны байдлаар нийт 249 хүн харшлах өвчин эмгэгийн улмаас архины эмчилгээнд бүрэн хамрагдаж чадаагүй байна.

Иймээс албадан эмчилгээнд явуулах тухай эмнэлгийн дүгнэлт гаргахад тухайн хүн албадан эмчилгээ хийлгэхэд харшлах өвчин эмгэгтэй эсэхийг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг шинжилгээ хийж тогтоосон байхыг шаардаж, харшлах өвчин эмгэгтэй тохиолдолд албадан эмчилгээнд явуулж болох эсэхийг тогтоох заалт орууллаа.

Тухайн хүнд сонголт хийх боломж олгох зорилгоор согтуурах, мансуурах донтой гэсэн эмнэлгийн дүгнэлт гарсны дараа өөрөө сайн дураараа эмчилгээ хийлгэх хүсэлтээ бичгээр гаргасан нөхцөлд албадан эмчилгээнд явуулахгүй байхаар, хэрэв хуульд заасан хугацаанд сайн дураараа эмчлүүлэхгүй байвал албадан эмчилгээнд явуулах тухай зохицуулалт нэмсэн.

Албадан эмчлэх эмнэлэгт эмчлүүлэхээр ирж байгаа хүнийг хүлээн авах ажиллагааг одоо мөрдөж байгаа хуульд зааснаас илүү дэлгэрэнгүй тусгалаа.

Судалгаанаас үзэхэд бусад оронд донтох өвчинтэй тэмцэх нь өндөр өртөг бүхий эмнэлгийн үйлчилгээ болж байдаг бөгөөд хэдий зардал, өртөг өндөр ч үр дүн нь нийгэмд хэмжихээргүй эерэг бол тухайн үйл ажиллагаанд хөрөнгө төсөвлөх хэрэгтэй гэж үзэх байр сууринаас ханддаг байна.

Одоогийн хуульд Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасныг хуулийн төсөлд хэвээр үлдээв.

Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6.6 дахь заалтад...”сэтгэцийн эмгэгийн /оношийн бүлгээр/ эмчилгээний төлбөрийг төр хариуцахаар заасан болно.

Албадан эмчлэх эмнэлгийн зардалд тооцож оруулах шаардлагатай эмчилгээнд хамрагдаж байгаа хүнд илэрсэн бусад өвчин эмгэгийг эмчлэх, эмнэлгийн хувцас, эмчилгээний хоолны болон өвчтөний ирэх, буцах зардлыг холбогдох зүйлд тусгайлан заалаа.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд архидан согтуурахтай тэмцэх сангийн хөрөнгийг архинд донтох өвчтэй хүнд үзүүлэх үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулахаар заасныг үндэслэн Албадан эмчлэх эмнэлгийн санхүүжилтэд Архидан согтуурахтай тэмцэх сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, иргэний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр байж болохоор заалаа.

Албадан эмчилгээний үр дүнг алдагдуулахгүй байх, албадан эмчилгээнээс зайлсхийх явдлыг гаргуулахгүй байх, эмчлүүлэгчийн нийгмийн байдлыг дээшлүүлэх зорилгоор тодорхой мэргэжилгүй, ажилгүй эмчлүүлэгчдэд зориулан албадан эмчлүүлэх хугацаанд нь нөхөн сэргээх хөдөлмөр эмчилгээтэй уялдуулан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг явуулж болох тухай зүйл орууллаа.

Төсөлд эмчлүүлэгчийн эрх үүргийг зааж, эмчлүүлэгч өөртөө болон бусдад аюултай үйлдэл хийж болзошгүй байдалд орсон тохиолдолд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд заасан журмын дагуу тусгаарлах болон номхотгох аргыг хэрэглэж болохоор заалт нэмлээ.

Нийгмийн халамжийн тухай хуульд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөлд сургалт зохион байгуулах, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр байрлуулан асрамжлах зэрэг үйлчилгээ байхаар, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд согтуурах, мансуурах донтох өвчтэй иргэн хамаарахаар заасныг үндэслэн нийгмийн халамжид хамруулах зохицуулалт орууллаа.

Хуулийн төсөл нь 4 бүлэг, 23 зүйлтэй ба дөрөвдүгээр бүлэгт албадан эмчлүүлсний дараа авах арга хэмжээний талаар тусгалаа.

Хуулийн төслийг тус яам болон Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг боловсруулав.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ